

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/116/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/116/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.03 № 123

танай _____ -ны № _____ -т

ДАРИВ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Н.ЦОГДЭЛГЭР
ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар:

- Байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, тооцоо, бодоогүй,
- Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 99 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан,
- Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 2,051.5 мянган төгрөг хасагдсан,
- Худалдан авсан 29,037.9 мянган төгрөгийн тээвэр шатахууныг анхан шатын баримт үндэслээгүй, бөөн дүнгээр орлого авч, 21,070.2 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан,

822511000367

- Цалингийн зардлын төсвөөс ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл 45,211.2 мянган төгрөг гүйлгэн зарцуулж, тайлагнасан,
- Албан хаагчдын 3 дугаар улирлын ажлын үр дүнг үнэлээгүй, тушаал шийдвэргүйгээр 17,264.8 мянган төгрөгийн урамшууллыг 7 дугаар сард урьдчилан олгосон,
- Цалингийн зөрүү гэж 3 албан хаагчдад 5,884.2 мянган төгрөг илүү бодож олгосон, цалингийн 1,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй, авлагаар тайлагнаагүй,
- Тайлант онд 4,571.9 мянган төгрөгийн хоол, хүнсний материалыг орлого аваагүй, зарлага болгосон зэрэг зөрчил илэрсэн.

Эдгээр алдаа зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5, 41 дүгээр зүйлийн 41.2, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 8 дугаар зүйлийн 8.2, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11 дүгээр тогтоолтой нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн бодитой байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд 1512 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн ба өмнөх оны авлага барагдуулж 158,323.0 мянган төгрөгийг санхүүжилт олгосон байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 25,19.7 мянган төгрөгийн, хандив тусламжаар ирсэн 50,237.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

Аудитын гол асуудал

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 997,037.7 мянган төгрөг нэхэмжилснээс 871,359.0 мянган төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэж, 2,051.5 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж, 123,627.2 мянган төгрөг авлагаар тайлагнасан байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2025 оны 08 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж тогтмол зардлыг 10,647.9 мянган төгрөгөөр бууруулж баталснаас түлш халаалт зардлын 11,102.4 мянган төгрөгийн өртэй гарсан байна.

Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргаагүй, дотоод хяналт үр нөлөөгүй байгаа нь төсөв, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, өр төлбөр үүсэх, санхүүгийн үйл ажиллагаа доголдох зэрэг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжүүлэхээр сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан гүйцэтгэлээр 75.6 хувиар дүгнэсэн боловч баталгаажуулаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулан ажиллаж, гэрээний биелэлт 88.1 хувь байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудитхийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан СТ-1 (төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	5,142,523.76	88,977,794.37
Банканд байгаа бэлэн мөнгө/ төгрөгөөр/	5,142,523.76	88,977,794.37
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгө	5,142,523.76	88,977,794.37
АВЛАГА	172,726,877.54	131,097,028.74
Төлбөртэй үйлчилгээний авлага	158,323,044.52	123,627,161.72
Ажиллагчидтай холбогдсон авлага	10,055,519.02	2,643,903.02
Байгууллагаас авах авлага		477,650.00
Хувь хүмүүсээс авах авлага	4,348,314.00	4,348,314.00
БАРАА МАТЕРИАЛ	63,964,992.83	63,459,429.76
Түүхий эд материал	31,704,899.77	39,555,146.70
Эм боох материал	31,704,899.77	39,555,146.70
Хангамжийн материал	32,260,093.06	23,904,283.06
Бичиг хэргийн материал	122,500.00	240,000.00
Аж ахуйн материал	28,573,593.06	22,017,583.06
Түлш, шатах тослох материал		30,000.00
Барилгын засварын материал	263,500.00	206,000.00
Хүнсний материал	3,300,500.00	960,700.00
Бусад хангамжийн материал		450,000.00
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	241,834,394.13	283,534,252.87
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,591,180,659.16	1,553,210,878.86
Биет хөрөнгө	1,569,907,309.16	1,531,974,428.86
Барилга, байгууламж, орон сууц	1,319,176,398.00	1,329,176,398.00
Хуримтлагдсан элэгдэл	-126,060,729.42	(160,252,351.43)
Авто-тээврийн хэрэгсэл	294,210,000.00	340,948,221.77
Хуримтлагдсан элэгдэл	-72,435,000.18	(103,967,351.86)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	384,796,465.60	394,471,165.60
Хуримтлагдсан элэгдэл	-242,285,335.03	(285,445,526.18)
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,013,060.00	21,058,060.00
Хуримтлагдсан элэгдэл	-10,129,166.66	(13,017,500.44)
Бусад үндсэн хөрөнгө	10,667,500.00	14,166,600.00
Хуримтлагдсан элэгдэл	-3,302,683.15	(5,420,086.60)
Ном	256,800.00	256,800.00
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	21,273,350.00	21,236,450.00
Хуримтлагдсан элэгдэл	1,119,000.00	1,119,000.00
Бусад биет бус хөрөнгө	-768,450.00	(805,350.00)
Хуримтлагдсан элэгдэл	20,922,800.00	20,922,800.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,591,180,659.16	1,553,210,878.86
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,833,015,053.29	1,836,745,131.73
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Ажилчидтай холбогдсон өглөг	981,981.30	981,981.30

Бараа үйлчилгээний зардлын өглөг		15,949,202.46
Байгууллагад төлөх өглөг	14,581,062.92	14,594,615.02
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	15,563,044.22	31,525,798.78
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	15,563,044.22	31,525,798.78
Засгийн газрын хувь оролцоо	172,487,090.33	172,487,090.33
Дахин үнэлгээний нэмэгдэл	104,457,837.06	104,457,837.06
Хуримтлагдсан үр дүн	1,540,507,081.68	1,528,274,405.56
Өмнөх үеийн үр дүн	1,275,736,950.18	1,540,507,081.68
Тайлант үеийн үр дүн	264,770,131.50	(12,232,676.12)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,817,452,009.07	1,805,219,332.95
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,833,015,053.29	1,836,745,131.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан СТ-2 (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ	ТАЙЛАНТ ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	904,722,889.05	1,028,564,469.40
Орон нутгийн төсвөөс	36,959,400.00	33,578,300.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	867,763,489.05	994,986,169.40
Бараа, үйлчилгээний орлого	250,550,589.68	59,271,092.39
Хандивын тусламжийн орлого Үндсэн хөрөнгө	238,963,925.40	50,237,321.77
Хандивын тусламжийн орлого Бараа материал	11,551,664.28	9,033,770.62
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	35,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,155,273,478.73	1,087,835,561.79
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	578,776,426.85	762,093,471.39
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	524,551,802.05	730,249,960.21
Үндсэн цалин	362,254,097.33	403,275,187.61
Нэмэгдэл	109,041,063.24	274,198,523.83
Унаа хоолны хөнгөлөлт	4,588,000.00	4,834,758.95
Урамшуулал	48,668,641.48	47,941,489.82
Нийгмийн хамгааллын шимтгэл	54,224,624.80	31,843,511.18
Тэтгэврийн даатгал	37,357,141.20	21,599,555.02
Тэтгэмжийн даатгал	4,218,955.40	2,445,153.86
ҮОМШӨ-ний даатгал	2,100,389.70	1,857,788.38
Ажилгүйдлийн даатгал	2,109,727.70	1,629,222.38
Эрүүл мэндийн даатгал	8,438,410.80	4,311,791.54
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	310,257,660.96	332,974,766.52
Тогтмол зардал	35,525,140.58	39,680,756.46
Гэрэл цахилгааны зардал	2,312,940.58	3,143,156.46
Түлш, халаалтын зардал	33,112,200.00	36,537,600.00
Цэвэр, бохир усны зардал	100,000.00	
Нормативт зардал	128,084,413.61	106,783,275.99
Эм	117,818,713.61	92,152,855.99
Хоол	10,265,700.00	14,630,420.00

Хангамж бараа үйлчилгээний зардал	39,526,005.17	58,262,360.00
Бичиг хэргийн материал	4,044,350.00	3,819,400.00
Тээвэр, шатахууны зардал	22,213,425.00	33,009,750.00
Шуудан холбооны зардал	1,941,850.00	2,182,400.00
Хог хаягдал зайлуулах зардал		60,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл	9,597,800.00	19,190,810.00
Бараа материал акталсан зардал	1,728,580.17	1.00
Эд хогшил урсгал засварын зардал	344,800.00	4,495,900.00
Тавилга		806,000.00
Урсгал засвар	170,500.00	3,689,900.00
Томилолт зочны зардал	1,772,000.00	1,528,000.00
Дотоод томилолтын зардал	1,772,000.00	1,528,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,602,100.00	3,877,022.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,602,100.00	3,200,000.00
Маягт хэвлүүлэх зардал		677,022.00
Бараа үйлчилгээний бусад зардал	103,403,201.60	118,347,452.07
Бусад зардал	3,384,020.00	4,420,650.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,019,181.60	113,926,802.07
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,469,259.42	5,000,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,469,259.42	5,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,469,259.42	5,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	890,503,347.23	1,100,068,237.91
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	264,770,131.50	(12,232,676.12)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	264,770,131.50	(12,232,676.12)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого		
Орон нутгийн төсвөөс	36,994,400.00	33,578,300.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	715,243,791.53	1,029,682,052.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	752,238,191.53	1,063,260,352.20
Ажиллагчидтай холбогдсон зардал	587,849,964.58	754,681,855.39
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	533,625,339.78	722,838,344.21
Үндсэн цалин	307,377,030.49	395,863,571.61
Нэмэгдлүүд	149,114,380.21	274,198,523.83
Унаа хоолны хөнгөлөлт	5,032,372.54	4,834,758.95
Урамшуулал	72,101,556.54	47,941,489.82
Нийгмийн хамгааллын шимтгэл	54,224,624.80	31,843,511.18
Тэтгэврийн даатгал	37,357,141.20	21,599,555.02
Тэтгэмжийн даатгал	4,218,955.40	2,445,153.86
ҮОМШӨ-ний даатгал	2,100,389.70	1,857,788.38
Ажилгүйдлийн даатгал	2,109,727.70	1,629,222.38

Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Эрүүл мэндийн даатгал	8,438,410.80	4,311,791.54
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	153,048,664.91	194,023,526.20
Тогтмол зардал	35,525,140.58	28,578,300.00
Гэрэл цахилгааны зардал	2,312,940.58	3,143,156.46
Түлш, халаалтын зардал	33,112,200.00	25,435,143.54
Цэвэр, бохир усны зардал	100,000.00	-
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	78,798,694.33	103,967,454.20
Эм	68,122,494.33	88,479,384.20
Хоол	8,401,200.00	13,488,070.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,275,000.00	2,000,000.00
Хангамж бараа үйлчилгээний зардал	27,055,325.00	41,172,650.00
Бичиг хэрэг	2,527,000.00	3,112,300.00
Тээвэр, шатахуун	18,186,975.00	32,898,350.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,941,850.00	2,182,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	595,000.00	215,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,804,500.00	2,764,600.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,668,105.00	10,800,300.00
Багаж, техник, хэрэгсэл	945,805.00	8,713,800.00
Урсгал засвар	1,722,300.00	2,086,500.00
Томилолт, зочны зардал	1,772,000.00	1,528,000.00
Дотоод албан томилолт	1,772,000.00	1,528,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,128,300.00	4,519,622.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,703,300.00	3,200,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	425,000.00	1,319,622.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,101,100.00	3,457,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,101,100.00	3,457,200.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,469,259.42	5,000,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,469,259.42	5,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,469,259.42	5,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	742,367,888.91	953,705,381.59
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,870,302.62	109,554,970.61
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	20,489,000.00	25,719,700.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	20,489,000.00	25,719,700.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(20,489,000.00)	(25,719,700.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	(10,618,697.38)	83,835,270.61
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,761,221.14	5,142,523.76
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,142,523.76	88,977,794.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТА - 4
(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	172,487,090.33	104,457,837.06	1,275,736,950.18	1,552,681,877.57
Залруулсан үлдэгдэл	172,487,090.33	104,457,837.06	1,275,736,950.18	1,552,681,877.57
Тайлант үеийн үр дүн	-	-	264,770,131.50	264,770,131.50
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	172,487,090.33	104,457,837.06	1,540,507,081.68	1,817,452,009.07
Залруулсан үлдэгдэл	172,487,090.33	104,457,837.06	1,540,507,081.68	1,817,452,009.07
Тайлант үеийн үр дүн	-	-	(12,232,677.12)	(12,232,677.12)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	172,487,090.33	104,457,837.06	1,528,274,404.56	1,805,219,331.95

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан СТ-4-1 (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Татаас, санхүүжилтийн орлого	1,221,020,000.00	1,029,682,052.20	191,337,947.80	84.3
Эрүүл мэндийн даатгалын сангаас	1,221,020,000.0	1,029,682,052.20	191,337,947.80	84.3
Бараа, үйлчилгээний орлого	5,142,500.00	-	5,142,500.00	-
Урьд оны үлдэгдлээс	5,142,500.00		5,142,500.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,226,162,500.00	1,029,682,052.20	196,480,447.80	84.0
Ажиллагчидтай холбогдсон зардал	987,084,600.00	754,681,855.39	232,402,744.61	76.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	877,630,200.00	722,838,344.21	154,791,855.79	82.4
Үндсэн цалин	424,201,200.0	395,863,571.61	28,337,628.39	93.3
Нэмэгдэл	372,299,600.0	274,198,523.83	98,101,076.17	73.6
Унаа хоолны хөнгөлөлт	19,218,900.0	4,834,758.95	14,384,141.05	25.2
Урамшуулал	61,910,500.0	47,941,489.82	13,969,010.18	77.4
Нийгмийн хамгааллын шимтгэл	109,454,400.00	31,843,511.18	77,610,888.82	29.1
Тэтгэврийн даатгал	73,786,700.0	21,599,555.02	52,187,144.98	29.3
Тэтгэмжийн даатгал	8,917,000.0	2,445,153.86	6,471,846.14	27.4
Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	4,458,400.0	1,857,788.38	2,600,611.62	41.7
Ажилгүйдлийн даатгал	4,458,400.0	1,629,222.38	2,829,177.62	36.5

Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Эрүүл мэндийн даатгал	17,833,900.0	4,311,791.54	13,522,108.46	24.2
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	234,077,900.00	191,164,926.20	32,327,673.80	81.7
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	109,383,400.00	103,967,454.20	5,415,945.80	95.0
Эм, боох материал	94,339,000.0	88,479,384.20	5,859,615.80	93.8
Хоол, хүнс	13,412,000.0	13,488,070.00	(76,070.00)	100.6
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	1,632,400.0	2,000,000.00	(367,600.00)	122.5
Бусад бараа үйлчилгээний зардал	54,089,500.00	41,172,650.00	2,331,550.00	95.7
Бичиг хэргийн материал	3,051,000.0	3,112,300.00	(61,300.00)	102.0
Тээвэр, шатахууны зардал	44,892,500.0	32,898,350.00	11,994,150.00	73.3
Шуудан холбооны зардал	2,000,000.0	2,182,400.00	(182,400.00)	109.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	215,000.00	1,785,000.00	10.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,146,000.0	2,764,600.00	(618,600.00)	128.8
Жижиг эд хогшил худалдан авах зардал	58,750,000.00	36,520,000.00	22,230,000.00	62.2
Багаж, техник, хэрэгсэл	55,000,000.0	32,708,500.00	22,291,500.00	59.5
Урсгал засварын зардал	3,750,000.0	3,811,500.00	(61,500.00)	101.6
Томилолт зочны зардал	3,400,000.0	1,528,000.0	1,872,000.00	44.9
Дотоод томилолтын зардал	3,400,000.00	1,528,000.00	1,872,000.00	44.9
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,955,000.00	4,519,622.00	435,378.00	91.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,200,000.0	3,200,000.00	-	100.0
Маягт хэвлүүлэх зардал	1,755,000.00	1,319,622.00	435,378.00	75.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,457,200.00	42,800.00	98.8
Бусад зардал	3,500,000.00	3,457,200.00	42,800.00	98.8
<u>Урсгал шилжүүлэг</u>	5,000,000.00	-	5,000,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	-	5,000,000.00	-
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,226,162,500.00	945,846,781.59	280,315,718.41	77.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,142,523.76	5,142,523.76	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	88,977,794.37	-	-

**2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсвийн/ СТ-4-2 /
(төгрөгөөр)**

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого				
Татаас, санхүүжилтийн орлого	33,578,300.00	28,578,300.00	5,000,000.00	85.1
Орон нутгийн төсвөөс	33,578,300.00	28,578,300.00	5,000,000.00	85.1
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	-	-	-	-
Тогтмол зардал	33,578,300.00	28,578,300.00	5,000,000.00	85.1
Гэрэл цахилгааны зардал	2,588,500.0	3,143,156.46	(554,656.46)	121.4
Түлш, халаалтын зардал	25,889,800.0	25,435,143.54	454,656.46	98.2
Цэвэр бохир ус	100,000.0	-	100,000.00	-
Урсгал зардал	5,000,000.00	-	5,000,000.00	-
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	33,578,300.00	28,578,300.00	5,000,000.00	85.1

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 2,361,793.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй тайлантай холбоотой:** НДШ-ийн авлагыг 7,411.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, халаалтын зардлын 11,102.4 мянган төгрөгийн өглөгийг бүртгэлд тусгаагүй, хандив тусламжаар ирсэн 21,838.9 мянган төгрөгийн автомашин орлого аваагүй алдааг залрууллаа.
- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим системд 2,321,440.9 мянган төгрөгийн 65 мэдээллийг нөхөн байршуулсан.

Залруулагдаагүй 146,267.7 мянган төгрөгийн 14 зөрчил илэрсэн нь материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн тул “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн 139,383.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 зөвлөмж, 1 албан шаардлага, 6,884.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, хариуцлага тооцох 2 албан шаардлага өгсөн.

3.2 Төлбөрийн акт:

1. Албан хаагч Г.Энхдэлгэрт цалингийн урьдчилгаа 1,000.0 мянган төгрөгийн олгосон боловч суутган тооцоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д” батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т”дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянах, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Эрүүл мэндийн төвийн дарга Н.Цогдэлгэрт 8, 12 дугаар сард 1,352.8 мянган төгрөг, нягтлан бодогч Э.Нямдаваад 2, 7, 8, 10, 11, 12 дугаар сард 3,759.6 мянган төгрөг, сувилагч Ч.Дэлгэрзаяад 1, 2 дугаар сард 771.8 мянган төгрөгийг цалингийн зөрүү гэж үндэслэлгүй нийт 5,884.2 мянган төгрөг бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага:

1. Байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, тооцоо, бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу хөрөнгийн тооллого хийж үр дүнг хэлэлцэж, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2024 оны 01/16, 2025 оны 01/29 дугаар төлбөрийн акт, 2024 оны 11/27, 10/27, 06/48 дугаар албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй, байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 146,267.7 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрч “Сөрөг дүгнэлт” авсан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т “албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын шийдвэр хэрэгжүүлээгүй албан үүргээ биелүүлээгүй Эрүүл мэндийн төвийн даргад хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

3. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2024 оны 01/16, 2025 оны 01/29 дугаар төлбөрийн акт, 2024 оны 11/27, 10/27, 06/48 дугаар албан шаардлагуудыг

хэрэгжүүлээгүй, байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 146,267.7 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрч "Сөрөг дүгнэлт" авсан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" 20.2.6-т "бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын шийдвэр хэрэгжүүлээгүй албан үүргээ биелүүлээгүй Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Тус байгууллага нь албан хаагчдын 3 дугаар улирлын үр дүнг үнэлээгүй, тушаал шийдвэргүйгээр 17,264.8 мянган төгрөгийн урамшууллыг 7 дугаар сард урьдчилан олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно", 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий этгээдийн тушаал шийдвэрийг үндэслэн албан хаагчдийн ажлыг үнэлж урамшууллыг олгож байх.

Хоёр. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

1.Илрүүлэлт: Авлагын үлдэгдлээс 7,469.8 мянган төгрөг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалт "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө, хянан баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан гаргахын өмнө авлагын тооцоо нийлж баталгаажуулж байх

2.Илрүүлэлт: өглөгийн үлдэгдлээс 12,706.5 мянган төгрөг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалт “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө, хянан баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан гаргахын өмнө өглөгийн тооцоо нийлж баталгаажуулж байх

3.Илрүүлэлт: Хоол, хүнсний материалын 4,571.9 мянган төгрөг орлого аваагүй, зарлага болгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоол хүнсний материалыг анхан шатын баримтыг /зарлагын падааныг/ үндэслэн нярваар орлого авхуулах, хоол хүнсний материалыг батлагдсан хоолны менюны дагуу шаардах хуудас хөтлөн зарлага гаргах.

4. Илрүүлэлт: Худалдан авсан 29,037.9 мянган төгрөгийн тээвэр шатахууныг бөөн дүнгээр орлого авсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууныг анхан шатын баримтыг /зарлагын падааныг/ үндэслэн нярваар орлого авахуулах, шатахууныг жолоочийн замын тооцооны хуудас, шатахуун олгосон тасалбар үндэслэн шаардах хуудас хөтлөн зарлага гаргах.

5. Илрүүлэлт:Тээвэр шатахууны зардлаас 21,070.2 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.

Гурав. Хандив тусламжаар ирсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 99 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3-т "хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл", Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2025 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т "Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах, дахин үнэлгээ хийх зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт, зөвлөмж гаргуулж ажиллах.

Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй холбоотой

Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 2,051.4 мянган төгрөг хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.1 даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Тав. Зориулалт бус зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Цалингийн зардлаас ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл рүү 45,211.2 мянган төгрөг гүйлгэн зарцуулж, тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал "Ангилал шинэчлэн батлах тухай"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд эдийн засгийн ангиллын дагуу төсвийг үр ашигтай зарцуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
	Шилэн дансны цахим системд 2,321,440.9 мянган төгрөгийн 65 мэдээллийг ил тод байршуулаагүй,	1	2,321,440.9	1	2,321,440.9	-	-	1	2,321,440.9	-	-	-	-
	Хандив тусламжаар ирсэн 21,838.9 мянган төгрөгийн авто машин орлого аваагүй	1	21,838.9	1	21,838.9			1	21,838.9	-	-	-	-
	Халаалтын зардлын 11,102.4 мянган төгрөгийн өглөгийг бүртгэлд тусгаагүй	1	11,102.4	1	11,102.4			1	11,102.4				
	ЭМНДШ-ийн авлагыг 7,411.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	7,411.6			1	7,411.6	1	7,411.6				
Дүн		4	2,361,793.8	1	2,354,382.2	1	7,411.6	4	2,361,793.8	-	-	-	-

Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан санхүүгийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2 Цалингийн зардлаас ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл рүү 45,211.2 мянган төгрөг гүйлгэн зарцуулж тайлагнасан	3	4	5	6	7	8	9	10
		1	45,211.2	-	-	-	-	1	45,211.2
	Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 99 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан	1	-	-	-	-	-	1	-
Дарив сумын эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 2,051.5 мянган төгрөг хасагдсан	1	2,051.5	-	-	-	-	1	2,051.5
	Тус байгууллага нь албан хаагчдын 3 дугаар улирлын үр дүнг үнлээгүй, тушаал шийдвэргүйгээр 17,264.8 мянган төгрөгийг 7 дугаар сард урьдчилан олгосон.	1	17,264.8	-	-	-	-	1	17,264.8
	Авлагын үлдэгдлээс 7,469.8 мянган төгрөг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	7,469.8	-	-	-	-		7,469.8
	Өглөгийн үлдэгдлээс 12,706.5 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	12,706.5					1	12,706.5
	Хоол хүнсний материалын 4,571.9 мянган төгрөг орлого аваагүй, зарлага болгосон,	1	4,571.9	-	-	-	-		4,571.9
	Худалдан авсан 29,037.9 мянган төгрөгийн шатахууныг анхан шатын баримт үндэслэн орлого аваагүй, бөөн дүнгээр орлого авсан	1	29,037.9					1	29,037.9



Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тээвэр шатахууны зардлаас 21,070.2 мянган төгрөгийг анхан шатныбаримтгүйгээр зарцуулсан.	1	21,070.2	-	-	-	-	1	21,070.2
Албан хаагч Г.Энхдэлгэрт цалингийн урьдчилгаа 1,000.0 мянган төгрөгийн олгосон боловч суутган тооцоогүй	1	1,000.0	1	1,000.0	-	-	-	-
Цалингийн зөрүү гэж Эрүүл мэндийн төвийн дарга Н.Цогдэлгэрт 8,12 дугаар сард 1,352.8 мянган төгрөг, няглан бодогч Э.Нямдаваад 2,7,8,10,11,12 дугаар сард 3,759.6 мянган төгрөг,сувилагч Ч.Дэлгэрзаяад 1,2 дугаар сард 771.8 мянган төгрөг нийт 5,884.2 мянган төгрөг илүү бодож олгосон.	1	5,884.2	1	5,884.2	-	-	-	-
Байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, тооцоо, бодоогүй	1	-	-	-	1	-	-	-
Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2024 оны 01/16 дугаартай, 2025 оны 01/29 дугаартай төлбөрийн акт, 2024 оны 11/27, 10/27 дугаартай, 06/48 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй	1	-	-	-	1	-	-	-
Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 146,267.7 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрч "Сөрөг	1	-	-	-	1	-	-	-
Нийт дүн	14	146,267.7	2	6,884.2	3	0	7	139,383.5



Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өрчлөлтий	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1					1		
	НИЙТ	1	1					1		

Б. Ариунтүвшин
ХТЭГЭЛЭЛЭН
2025